



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 01 өдөр

Дугаар A/154

Сүхбаатар сум

### Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3. "а", 29 дүгээр зүйлийн 29.2, "Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8, 12 дугаар зүйлийн 12.1, 22 дугаар зүйлийн 22.2, 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2, Зэсгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 41 дүгээр тогтоослыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн эрүүл мэнд, мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, гоц халдварт, халдварт, паразиттах өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал, амьтны өвчлөлийн байдлыг бүртгэх мэдээлэх, ажил үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах, хяналт тавих зорилгоор аймгийн хэмжээнд Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний хүрээнд дазаах арга хэмжээг авч, хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай. Үүнд:

2.1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2019 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 5 дугаар сарын 20-ны хооронд мал амьтны гоц халдварт, халдваргүй, паразиттах өвчин гарах, тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Мал эмнэлэг, эрүүл ахуй, ариутгал халдваргүйтгэлийн сарын аян"-ыг олсон нийтийг хамруулан чанартай зохион байгуулж, шаардагдах ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис, хүн хүч, шатахуун, тээврийн хэрэгслийг өөрсдийн гамшгийн нөөц сангаас бүрдүүлж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах,

2.2. Лабораторийн оношилгоо, шинжилгээ, дархлаажуулалт, угаалга, туулгалт, боловсруулалтад эрсдэлтэй бүсийн мэдрэмтгий мал, амьтныг технологит хугацаанд бүрэн хамруулах

2.3. Гоц халдварт өвчний голомт бүхий нутгаас мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэх, тууварлах, шаардлагагүй нөхцөлд малын гоц халдварт өвчний голомт бүхий аймаг, сумдад зорчихгүй байх, хүн мал, амьтны шилжилт хөдөлгөөнд байнга хяналт тавьж ажиллах.

2.4. Мал амьтны гоц халдварт шүлхий, цэцэг, Африк гахайн мялзан өвчний голомт бүхий нутагт тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр /ДУК/ ариутгал халдваргүйжүүлэлтийг шуурхай зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.5. Дээрх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг сумдын Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулан чанартай шуурхай гүйцэтгэхэд удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах.

3. Био бэлдмэл, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих, орон нутагт сарын аян, нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга /С.Ариунтөгс/-т үүрэг болгосугай.

4. Уг арга хэмжээний үр дүнг хянах сериомониторинг хийхэд шаардлагатай заэдлыг аймгийн 2019 оны төсөвт батлагдсан мал эмнэлгийн үйлчилгээний заэдлын дүнгийн 1 хувиар тооцож санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлог гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-т үүрэг болгосугай.

5. “Мал эмнэлэг, эрүүл ахуй, ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аян”, “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ний явцад хариуцлагагүй хандсан малчин, мал бүхий иргэд, байгууллага, холбогдох албан тушаалтанд хуулийн хариуцлага хүлээлгэх, хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, Мал эмнэлгийн газрын дарга /С.Ариунтөгс/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ